

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

## Агуулга

1.Аудитын гэрчилгээ .....	2
2.Аудитын тайлан.....	4
2.1. Оршил .....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	8
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	8
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3.Менежментийн захидал.....	9
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	10
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	10
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	11
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	13
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	15
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	16
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	18
4.7 Аудит хийсэн төсвийн тохируулгын тайлан.....	19
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	22

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн, өмчийн бодлого зохицуулалтын газар



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

ГЭМТЭЛ СОГОГ СУДЛАЛЫН  
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЕРӨНХИЙ  
ЗАХИРАЛ Э.ГАЛБАДРАХ ТАНАА

2020.02.27 № 06/630  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Гэмтэл, согог судлалын үндэсний төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Гэмтэл, согог судлалын үндэсний төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Гэмтэл, согог судлалын үндэсний төвийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## **2.Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Гэмтэл согог судлалын үндэсний төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Гэмтэл согог судлалын үндэсний төвийн ерөнхий захирал Э.Галбадрах Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн цалингийн зардалтай холбоотой зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Гэмтэл согог судлалын үндэсний төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Гэмтэл согог судлалын үндэсний төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 11 дүгээр сарын 1-нээс 2020 оны 2 дугаар сарын 12-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 2 дугаар сарын 21-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Баян ташаагийн эх Аудит” ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Гэмтэл, согог судлалын үндэсний төв 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 1 дүгээр сарын 24-ны өдрийн 1/90 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

## **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Гэмтэл, согог судлалын үндэсний төвийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь ээлтэй эрсдэлгүй орчинд, мэргэшсэн хамт олон, дэлхийн жишигт нийцсэн оношилгоо үйлчилгээг үзүүлэхэд оршино.

Гэмтэл, согог судлалын үндэсний төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Гэмтэл согог, сэргээн засах, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх данснаас хасах, шилжүүлэх, журам батлах тухай ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоол
- Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 24 дүгээр тогтоол Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг /шинэчлэн батлагдсан/
- Монгол улсын Засгийн газрын 2019 оны 25 дүгээр тогтоол Төрийн үйлчилгээний зарим албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай /шинэчлэн батлагдсан
- Монгол улсын Засгийн газрын 2019 оны 276 дугаар тогтоол Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоох
- Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/548 тоот тушаалаар Эрүүл мэндийн салбарын төрийн албан хаагчдын хоол, унааны хөнгөлөлт нэмэгдэл, урамшууллын хэмжээг тогтоох тухай /2019 онд хэрэгжүүлсэн/

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Гэмтэл, согог судлалын үндэсний төв нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа “Санхүүгийн тооцоолох” ХХК-ийн Acolous программ хангамж ашиглаж байна.

Гэмтэл, согог судлалын үндэсний төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “бага” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Гэмтэл, согог судлалын үндэсний төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 13 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны хагас жилийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 16,996,805.3 мянган төгрөгөөс тооцон 169,968.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшин 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 31,981,423.9 мянган төгрөгийн 1 хувиар буюу 319,841.2 мянган төгрөг болж өөрчлөгдсөн нь төлөвлөлтийн үеийн материаллаг байдлын түвшинг 2019 оны хагас жилийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцсонтой холбоотой.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Гэмтэл, согог судлалын үндэсний төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,571,885.2 мянган төгрөгөөр буюу 6.6 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/мянган төгрөг/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	45,000.0	2,380.0	(42,620.0)
Урьдчилгаа			-
Бараа материал	1,150,354.7	1,410,718.8	260,364.1
Үндсэн хөрөнгө	22,744,793.8	20,955,164.4	(1,789,629.4)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>23,940,148.5</b>	<b>22,368,263.2</b>	<b>(1,571,885.3)</b>
Өр төлбөр		2,380.0	2,380.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	23,940,148.5	22,365,883.2	(1,574,265.3)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>23,940,148.5</b>	<b>22,368,263.2</b>	<b>(1,571,885.3)</b>

Авлага дансны үлдэгдэл буурсан нь урд оны нэмэлт санхүүжилтээс татан төвлөрүүлсэн 45,000.0 мянган төгрөг буцаан төлөгдсөнөөс шалтгаалсан ба тайлант оны нэмэлт санхүүжилтээс 2,380.0 мянган төгрөгийг төвлөрүүлж авлага үүсгэсэн байна.

Бараа материалын үлдэгдэл 152,551.6 мянган төгрөгөөр өссөн. Энэ нь гэнэтийн болон олныг хамарсан цаг үеийн бэлэн байдлын нөөц бэлтгэхтэй холбоотой юм.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн А-5/1375 тоот, 2019 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн 242 дугаар шийдвэрийг үндэслэж тоног төхөөрөмжийн данснаас 1,128,566.8 мянган төгрөг, тавилга хэрэгслийн данснаас 18,252.4 мянган төгрөг, нийт 1,146,819.2 мянган төгрөгийн хөрөнгийг акталсантай холбоотой байна.

Тайлант онд 145,952.1 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 118,117.2 мянган төгрөгийн тавилга хэрэгсэл, 400.0 мянган төгрөгийн ном худалдаж авсан бөгөөд бусад эх үүсвэрээс 24,968.0 мянган төгрөгийн түргэн тусламжийн авто машин, 137,481.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 3,576.0 мянган төгрөгийн тавилга хэрэгсэл үнэ төлбөргүй авсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл өссөн нь тайлант оны эцэст “Скай Хоукс” ХХК-д сургалт зохион байгуулахтай холбоотойгоор өдрийн хоолны зардал 2,380.0 мянган төгрөгийг шилжүүлсэн боловч нэр данс зөрүүтэйгээр буцаж дансанд орж, төвлөрүүлэх шилжүүлгээр татагдсантай холбоотой юм.

## 2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Гэмтэл согог судлалын үндэсний төв нь 2019 онд 1,217,961.4 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 2,959,287.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 243 хувиар биелүүлсэн байна. Орлогын төлөвлөгөө 143 хувиар илүү биелсэн байгаа нь орлого төвлөрүүлэх төлөвлөгөөг үндэслэл муутай хийсэн гэж үзэж байна.

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 31.412.697.5 мянган төгрөгийн төсөв батлагдсан, үүнээс 31,125,435.3 мянган төгрөгийг урсгал зардалд, 287,262.2 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар хуваарилсан байна.

Нийт зардлын 9,064,207.2 мянган төгрөгийг улсын төсвөөс, 21,130,528.9 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 1,217,961.4 мянган төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гэмтэл согог судлалын үндэсний төв нь 2019 онд 31,412,697.5 мянган төгрөгийн урсгал төсвийг зарцуулахаар батлагдсанаас 30,071,142.7 мянган төгрөгийн зардал гаргаж төсвийг 1,365,929.5 мянган төгрөгөөр буюу 4.3 хувиар хэмнэж ажилласан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

**Нэмэлт төсөв:** Эрүүл мэндийн яамнаас 178,683.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 471,945.2 мянган төгрөг, төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан 61,004.2 мянган төгрөг, нийт 711,632.4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж ажилласан байна.

Үүнээс Эрүүл мэндийн сайдын 2017 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн А/394 дүгээр тушаалын дагуу гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчдод эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх журмыг таниулах сургалт семинарыг 10 аймаг, 2 дүүрэгт зохион байгуулсан сургагч багш нарын цалин хөлс 55,668.1 мянга, хангамж бараа материалын зардалд 25,615.7 мянга, норматив зардалд 183,820.0 мянга, эд хогшил худалдан авахад 113,573.4 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 285,200.5 мянган, нийт 705,381.7 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 6,250.0 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

## 2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 13 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 14 эрсдэл тодорхойлж нийт 14 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 123,970.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 3,000.0 мянган төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож, 31,547.8 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 89,422.3 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Үүнд:

1. Нэмэлт санхүүжилтийн данснаас баримтын бүрдэлгүй 3,000.0 мянган төгрөгийг хувь хүний харилцах дансанд шилжүүлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх,



санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэнтэй нийцэхгүй, “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох

2. Эмийн худалдан авалтанд хийсэн түүврээр "Айвыко Интернэшнл" ХХК нь 6, 10, 17-р багцад шалгарч 280,035.3 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг хуваарийн дагуу нийлүүлэх гэрээ байгуулснаас тухайн онд 367,590.2 мянган төгрөгийг шилжүүлж гэрээний дүнгээс 31,547.8 мянган төгрөгөөр илүү эм худалдан авсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34.1.3 дахь заалт “нэмэлт нийлүүлэлт нь анхны гэрээний үнийн 20 хувиас хэтрэхгүй нөхцөлд анхны гэрээний дагуу нийлүүлсэн бараа, тоног төхөөрөмжийн зарим хэсгийг солих, засварлах болон нэмж нийлүүлэх үед нийлүүлэгчийг өөрчлөх нь захиалагч өөр төрлийн техникийн үзүүлэлттэй материал авахад хүргэх, энэ нь ашиглалт болон засвар үйлчилгээнд техникийн хүндрэл учруулах, эсхүл үргүй зардал гаргахаар бол” гэсэнтэй нийцэхгүй, “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх

## **2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Гэмтэл согог судлалын үндэсний төв нь 2019 оны өндөр өртөгт, эм эмнэлгийн хэрэгсэл авах 17,817,452.1 мянган төгрөгийн тендерийн худалдан авах гэрээнээс “Мед Монгол” ХХК 3,904,168.9 мянган төгрөг буюу 33.2 хувь, “Агь фарма” ХХК 3,226,989.0 мянган төгрөг буюу 22.8 хувийг нийлүүлэлт хийж байгаа нь энэ 2 компанид илт давуу эрх үүсгэж байж болзошгүй харагдаж байна. Дараагийн аудитаар худалдан авах үйл ажиллагааг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## **2.12. Шилэн дансны мэдээлэл**

Гэмтэл согог судлалын үндэсний төв нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 147 удаагийн мэдээллийг хуулийн хугацаанд нь, 2 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

## **2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 408.558.7 мянган төгрөгийн зөрчилд 11,734.4 мянган төгрөгийн төлбөрийн 2 акт тогтоосныг барагдуулсан байна.

Нийт 7 зөвлөмж өгснөөс хэрэгжүүлж зөвлөмжийн хэрэгжилт 89.3 хувьтай байна.

## **2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Гэмтэл согог судлалын үндэсний төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Залруулагдаагүй 123,970.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тооцсон 319,841.2 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

“Зөрчилгүй” дүгнэлт

Гэмтэл согог судлалын үндэсний төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дугаар заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

### **3. Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### *1. Балансын данстай холбоотой асуудал*

##### 1.1. Илрүүлэлт:

Гэмтэл согог судлалын үндэсний төвийн ерөнхий захирлын 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн А/516 тоот тушаалыг үндэслэн 651 ажилтанд 89,422.3 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл олгосон. Үүнээс: 64 ажилтанд 25 хувиар ,587 ажилтанд 20 хувиар.

Энэ нь “эрх ба үүрэг” батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Засгийн газрын 2018 оны 382 дугаар тушаалын 4 дүгээр хавсралт Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журмын 3-д “Төрийн үйлчилгээний байгууллагын удирдах, гүйцэтгэх, туслах албан хаагчид төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлж байх хугацаанд нь ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг энэ журмын 4-т заасан шалгуур үзүүлэлтийн дагуу албан тушаалын сарын үндсэн цалингаас 10-25 хувиар тооцож, сар бүр олгоно” гэсэн заалт, Төсвийн тухай хуулийн 5.1.5, 6.4.1 дэхь заалтуудыг зөрчсөн.

##### 1.2. Эрсдэл:

Цалин, түүнтэй холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжилт хангагдахгүй байх

##### 1.3. Өгсөн зөвлөмж:

Засгийн газрын 2018 оны 382 дугаар тушаалын 4 дүгээр хавсралт Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журмыг мөрдөж ажиллах

##### 1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,195,354,721.38</b>	<b>1,413,098,831.37</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	-
<b>311</b>	<b>Кассанд байгаа бэлэн мөнгө</b>	-	-
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	-	-
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	45,000,000.00	2,380,000.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	45,000,000.00	2,380,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>1,150,354,721.38</b>	<b>1,410,718,831.37</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>266,966,093.50</b>	<b>340,307,068.43</b>
35110	Тусгай зориулалттай материал	148,699,664.00	69,488,975.34
35130	Эм боох материал	118,266,429.50	270,818,093.09
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>754,856,978.50</b>	<b>936,880,113.56</b>
35300	Бэлэн бүтээгдэхүүн	-	27,320,970.00
35410	Бичиг хэргийн материал	5,792,900.01	3,715,200.00
35420	Аж ахуйн материал	28,997,251.05	20,387,209.99
35430	Сэлбэг хэрэгсэл	591,841,049.78	649,763,049.78
35440	Түлш, шатах тослох материал	7,717,798.87	21,606,948.02
35450	Барилгын засварын материал	-	49,755,370.00
35460	Хүнсний материал	5,017,943.77	9,948,585.77
35470	Бусад хангамжийн материал	115,490,035.02	150,150,440.00
35500	Улсын мэдээллийн маягт	-	4,232,340.00
35600	Металл эдлэл	128,531,649.38	133,531,649.38
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>22,744,793,850.20</b>	<b>20,955,164,463.89</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>22,744,793,850.20</b>	<b>20,955,164,463.89</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>21,818,419,272.97</b>	<b>20,032,152,686.58</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	18,038,761,223.00	18,790,945,784.01
39202	Хуримтлагдсан элэгдэл	(6,804,656.76)	(395,820,229.24)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	284,939,954.33	309,907,995.33
39214	Бусад үндсэн хөрөнгө	775,807,461.01	23,622,900.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(10,980,500.40)	(6,399,343.92)
39217	Ном	14,593,219.00	14,993,219.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>926,374,577.23</b>	<b>923,011,777.31</b>
39301	Програм хангамж	7,256,000.00	7,256,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,310,000.00)	(2,310,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	935,344,140.00	935,344,140.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(13,915,562.77)	(17,278,362.69)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>23,940,148,571.58</b>	<b>22,368,263,295.27</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	<b>2,380,000.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	2,380,000.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	-	2,380,000.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	-	2,380,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	2,380,000.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>23,940,148,571.59</b>	<b>22,365,883,295.27</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>23,940,148,571.59</b>	<b>22,365,883,295.27</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	9,974,253,679.78	9,974,253,679.78
51101	Өмч: - төрийн	9,974,253,679.78	9,974,253,679.78
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>(2,021,261,318.17)</b>	<b>(3,595,526,594.49)</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	(2,021,261,318.17)	(2,021,261,318.17)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(1,574,265,276.32)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	15,987,156,209.98	15,987,156,209.98
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>23,940,148,571.59</b>	<b>22,368,263,295.27</b>

#### 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>28,743,667,591.98</b>	<b>30,407,158,577.18</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>3,024,209,241.98</b>	<b>3,288,663,339.90</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	2,966,886,241.98	3,112,180,311.90
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,916,528,575.08	2,959,287,341.90
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,726,572,526.88	2,900,624,095.53
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	14,311,453.00	58,663,246.37
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого БМ	175,644,595.20	176,843,028.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого ҮХ		152,532,970.00
120005	Түрээсийн орлого	50,357,666.90	-
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	57,323,000.00	
122001	Хандив тусламж /дотоод/	57,323,000.00	
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>25,719,458,350.00</b>	<b>27,118,495,237.28</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	261,457,150.00	666,632,419.28
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	4,760,000.00	61,004,250.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	228,165,150.00	133,683,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	28,532,000.00	471,945,169.28
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	6,026,957,300.00	8,698,239,700.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	6,026,957,300.00	8,698,239,700.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	19,431,043,900.00	17,753,623,118.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	19,431,043,900.00	17,753,623,118.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>30,308,159,949.40</b>	<b>31,862,129,034.30</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>30,308,159,949.40</b>	<b>29,640,704,563.49</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	30,122,412,879.79	29,414,286,997.74
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	7,883,030,046.22	9,382,160,220.00
210101	Үндсэн цалин	4,091,327,800.00	5,442,632,720.00
210102	Нэмэгдэл	2,763,922,100.00	2,579,728,500.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	488,017,021.00	880,075,000.00
210104	Урамшуулал	539,763,125.22	479,724,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	947,789,900.00	1,224,310,699.00
210201	Тэтгэврийн даатгал	635,535,188.00	836,127,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	79,042,500.00	93,078,799.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	59,450,712.00	78,694,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	15,796,500.00	19,673,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	157,965,000.00	196,736,000.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	659,161,569.80	687,331,328.88
210301	Гэрэл, цахилгаан	390,827,286.76	425,516,330.03
210302	Түлш, халаалт	126,963,582.00	135,446,493.07
210303	Цэвэр, бохир ус	141,370,701.04	126,368,505.78
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	327,771,428.23	569,839,089.60
210401	Бичиг хэрэг	21,015,319.99	43,952,423.01
210402	Тээвэр, шатахуун	65,583,738.62	75,190,862.85
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	26,219,893.62	23,440,045.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	168,513,620.00	157,834,756.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	46,438,856.00	269,421,002.74
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	4,456,514,784.41	4,882,168,477.03

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,866,595,373.24	4,183,259,642.01
210502	Хоол, хүнс	490,217,493.19	633,465,535.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	99,701,917.98	65,443,300.02
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>912,818,630.95</b>	<b>1,121,991,811.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	59,296,231.00	1,567,000.00
210602	Тавилга	5,500,000.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	23,843,900.00	5,923,500.00
210604	Урсгал засвар	824,178,499.95	1,114,501,311.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>72,387,150.00</b>	<b>35,971,800.00</b>
210701	Гадаад албан томиллолт	42,522,750.00	-
210702	Дотоод албан томиллолт	29,864,400.00	35,971,800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>155,829,718.00</b>	<b>110,535,770.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	91,785,490.00	45,299,360.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	12,000,000.00	12,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	3,366,440.00	4,925,900.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	725,800.00	725,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	159,814.00	-
210807	Газрын төлбөр	3,336,374.00	7,868,400.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	98,000.00	90,300.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	44,357,800.00	39,626,010.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>14,707,109,652.18</b>	<b>11,399,977,802.23</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,511,950,639.73	11,364,977,802.23
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	35,000,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	2,195,159,012.45	2,221,424,470.81
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>185,747,069.61</b>	<b>226,417,565.75</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>177,637,700.00</b>	<b>177,157,738.19</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	177,637,700.00	158,517,738.19
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	18,640,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>8,109,369.61</b>	<b>49,259,827.56</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,109,369.61	49,259,827.56
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(1,564,492,357.42)</b>	<b>(1,454,970,457.12)</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>183,405,988.00</b>	<b>119,294,819.20</b>
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	176,063,815.00	119,294,819.20
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	7,342,173.00	-
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>(183,405,988.00)</b>	<b>(119,294,819.20)</b>
